

ХОЁРДУГААР АЖЛЫН ХЭСЭГ- 2 дугаар хуралдаан  
 2015 оны 3 дугаар сарын 30- ны 15,00 цагт Уул уурхайн яамны 2 дугаар давхарын Хурлын  
 танхимд болж, 17,00 цагт төгсөв.  
 Ирц:

	Албан тушаал	Нэр	Ирсэн/Ирээгүй бол тайлбар
1	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны ХБОНГ-ын ахлах мэргэжилтэн	Б.Саран	Тулга орлож ирэв.
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ГУУ-ын улсын ахлах байцаагч	Ц. Мөнхцэцэг	Утас хаалттай.
3	Уул уурхайн яамны СБТГ-ын мэргэжилтэн	Т.Зууннаст	Ирсэн.
4	Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч	Н.Алгаа	Энхболд ирнэ гэсэн ч ирээгүй.
5	Монполимет ХХК-ийн гүйцэтгэх захирал	С.Энхтуяа	Хөдөө явсан, саналаа бичгээр өгнө гэв.
6	Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн	Л.Долгормаа	Гачигдал гарсан.
7	Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн	Б.Баярмаа	Ирсэн.
8	Байгаль орчны аудитын холбооны Удирдах зөвлөлийн дарга	Д.Энхээ	Хөдөө, Өмнөговь аймагт
9	МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн	Б.Батболд	Ирсэн.
10	Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо	Ц.Туяацэцэг	Ирсэн.
11	ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч	Ш.Цолмон	Ирсэн.

М.Тулга: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй бодлогын талаар товчхон танилцуулав. Байгаль орчины нөхөн сэргээлтийн асуудлыг зохицуулахдаа нарийвчилсан төлөвлөгөөг 5 жилийн хугацаатай батлуулж, жил бүр нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг тусгай дансанд байршуулдаг юм. Нөхөн сэргээлтийн ажлын биелэлт 85 хувиас дээш гэсэн дүгнэлтийг орон нутгийн удирдлагаас өгсөн бол түүнийг үндэслэн уг хөрөнгийг буцаан олгодог журамтай юм. Гэхдээ орон нутаг, төв хоёрт нэг тайлан очоод байна уу үгүй гэдэг дээр цаашид судалгаа хэрэгтэй үздэг. Нөгөө талаас Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам байгаль орчины менежментийн төлөвлөгөөг цахим хэлбэрт оруулж хяналтыг сайжруулах арга хэмжээ авч байна. Ирэх долоо хоногос цахим систем ажилд орох болов уу гэсэн найдлагатай байна. Цахим хэлбэрт оруулснаар төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг төв орон нутагт зэрэг хянаад явах боломжтой болно.

Хуралд ирсэн гишүүд саналаа солилцож, зөвлөлдсөний эцэст дараахь асуудлаар тохиролцов.

Тохирсон нь:

БОНХАЖЯ- М.Тулга- 50 хувийн барьцаа хөрөнгийн хүү тооцдог эсэхийг тодруулж Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулахаас гадна Яамны архивд сууж ажиллах журмын талаар мэдээлэл өгнө.

Гишүүд ашигт малтмал, тусгай зөвшөөрлийн төрлөөр байгаль орчины нөхөн сэргээлт, барьцааны тухай судалгааг 4 дүгээр сардаа багтаан хийж, дүнгээ танилцуулна.

Судалгааны хамрах болон шалгуур үзүүлэлт:

1. Уулын ажлын төлөвлөгөө, хайгуулын ажлын төлөвлөгөөтэй эсэх
2. Нарийвчилсан үнэлгээтэй эсэх
3. Үнэлгээ хийсэн компани, огноо
4. Байгаль орчины менежментийн төлөвлөгөө
5. Төлөвлөгөөний тайлан
6. Дүгнэлт
7. Төлөвлөсөн барьцаа 50 хувь
8. Тусгай дансанд оруулсан эсэх

Шалгуур үзүүлэлтийн дагуу судалгааг дараах компаниудаар хийнэ.

Арева- Батболд, Петрожайне- Долгормаа, Дунюань- Туяацэцэг, Алтайн хүдэр- Туяацэцэг, Монполимет-Энхтуяа, Борижгоны тал-Баярмаа, МТ- Зууннаст, Жи энд Юу Гоулд- Туяацэцэг, Тэгш плант-Баярмаа, Харанга ресурс-Туяацэцэг, Таван толгой- Туяацэцэг хариуцаж судалгааны дүнгээ танилцуулна.

Аспайер майнинг-ийн судалгааг Уул уурхайн ассоциац хийхээр тогтов.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн эрх зүйн зохицуулалтын судалгааг Туяацэцэг танилцуулна.

Тэмдэглэл хөтөлсөн Ш.Цолмон